



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах  
орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:


1.Дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтийг ханггуулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллахыг Онцгой байдлын хэлтсийн дарга (Б.Цогбадрах)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн A/04 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МОНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын ~~2025~~ оны ~~01~~ дугээр сарын ~~30~~-ны өдрийн  
~~1105~~ дугаар тогтоолын хавсралт



## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- |              |   |
|--------------|---|
| Дарга        | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга  |
| Орлогч дарга | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга  |
| Гишүүд       | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн<br>бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга  |
|              | Дүүргийн менежер  |
|              | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй,<br>төрийн байгуулалтын хорооны дарга  |
|              | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв,<br>санхүү, эдийн засгийн хорооны дарга  |
|              | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль<br>орчин, хүнс, хөдөө аж ахуйн хорооны дарга   |
|              | Хороодын Засаг дарга нар  |
|              | Дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга  |
|              | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга   |
|              | “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын дарга   |
|              | “Багахангайн төле камерын хяналтын дэд төв”<br>ОНӨААТҮГ-ын дарга  |
|              | Дүүргийн Улаан загалмайн хорооны дарга  |
|              | Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга   |
| Нарийн бичиг | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гамшгийн<br>эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, дотоод ажил,<br>бусад чиг үүрэг хариуцсан мэргэжилтэн |
|              | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн<br>эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан<br>мэргэжилтэн                                   |